

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	19
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН  
ГАЛЕРЕЙН ЗАХИРАЛ Б.САРАНТУЯА  
ТАНАА

2021.09.25 № 07/501  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын уран зургийн галерейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг хариуцлага**

Төрийн аудитын байгууллага нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



**Ц.НАРАНЧИМЭГ**

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,449,948.69</b>	<b>89,668,296.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	87.00	00.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	87.00	00.00
31110	Төгрөг	87.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>18,891,154.69</b>	<b>7,675,354.69</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	18,891,154.69	7,675,354.69
3351	Байгууллагаас авах авлага	4,980,000.00	404,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	13,911,154.69	7,271,154.69
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>82,558,707.00</b>	<b>81,992,942.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	420,000.00	420,000.00
35110	Тусгай зориулалттай материал	420,000.00	420,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	82,138,707.00	81,572,942.00
35410	Бичиг хэргийн материал	2,442,330.00	1,843,465.00
35420	Аж ахуйн материал	4,592,267.00	2,413,840.00
35470	Бусад хангамжийн материал	75,103,908.00	77,315,425.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,332,770,216.34</b>	<b>15,364,737,782.58</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	15,332,167,091.34	15,364,067,990.98
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	15,332,167,091.34	15,364,067,990.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,057,500.00	18,057,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,771,562.65	-9,781,145.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,403,205.75	72,144,671.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,603,552.69	-57,303,940.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,914,983.41	92,157,703.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,597,364.48	-54,359,771.61
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,249,905,700.00	15,301,294,792.00
39217	Ном	1,858,182.00	1,858,182.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	603,125.00	669,791.60
39301	Програм хангамж	2,020,000.00	2,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,416,875.00	-1,405,208.40
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>15,434,220,165.03</b>	<b>15,454,406,079.27</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>327,650.41</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	327,650.41	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	327,650.41	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	327,650.41	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,433,892,514.62</b>	<b>15,454,406,079.27</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,433,892,514.62	15,454,406,079.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	859,650,551.83	859,650,551.83
51101	Өмч: - төрийн	859,650,551.83	859,650,551.83
51102	- хувийн	00.00	00.00
51103	- хувьцаат	00.00	00.00
51104	Халаасны хувьцаа	00.00	00.00
51105	Нэмж төлөгдсөн капитал	00.00	00.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	00.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	259,517,726.79	280,031,291.44
51210	Өмнөх үеийн үр дүн	259,517,726.79	259,221,510.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	20,809,780.65
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,314,724,236.00	14,314,724,236.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,434,220,165.03</b>	<b>15,454,406,079.27</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>492,180,000.00</b>	<b>463,981,892.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>445,697,900.00</b>	<b>412,292,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	347,537,700.00	381,687,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,537,700.00	381,687,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	98,160,200.00	30,605,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,125,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,959,700.00	9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,200,500.00	15,480,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>442,525,062.13</b>	<b>443,172,111.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>442,525,062.13</b>	<b>443,172,111.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	432,433,143.42	407,189,081.93
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	159,857,128.00	149,504,379.10
210101	Үндсэн цалин	105,305,748.00	115,899,147.10
210102	Нэмэгдэл	24,536,380.00	14,963,232.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,015,000.00	18,642,000.00
210104	Урамшуулал	15,000,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,801,152.21	19,588,066.25
210201	Тэтгэврийн даатгал	14,181,165.34	13,638,080.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,415,942.79	1,604,576.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,155,651.63	1,108,223.65
210204	Ажилгүйдлийн даатгал	714,150.27	380,404.16
210205	Эрүүл мэндийн даатгал	2,334,242.18	2,856,781.62
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	126,225,000.00	126,225,000.00
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,684,008.18	18,184,766.82
210401	Бичиг хэрэг	3,310,500.00	2,585,165.00
210402	Тээвэр, шатахуун	2,586,398.00	1,230,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,839,247.68	2,990,196.82
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,000.00	905,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,097,862.50	10,473,315.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,328,900.00	5,291,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,328,900.00	5,291,960.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,252,130.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	14,252,130.00	8,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	747,900.00	00.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	747,900.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	65,213,200.00	53,379,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,201,200.00	49,551,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	114,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	897,500.00	1,714,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,323,725.03	27,015,309.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,640,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,323,725.03	20,375,309.76
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,091,918.71	35,983,029.42
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,100,000.00	14,327,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	13,917,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	410,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,991,918.71	21,655,529.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>49,654,937.87</b>	<b>20,809,780.65</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	00.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>49,654,937.87</b>	<b>20,809,780.65</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>445,997,900.00</b>	<b>412,292,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>300,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	300,000.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	300,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>445,697,900.00</b>	<b>412,292,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	347,537,700.00	381,687,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,537,700.00	381,687,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	98,160,200.00	30,605,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,125,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,959,700.00	9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	74,200,500.00	15,480,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>442,089,813.00</b>	<b>411,042,887.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>442,089,813.00</b>	<b>411,042,887.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>431,997,894.29</b>	<b>375,059,857.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>159,169,631.12</b>	<b>149,701,441.00</b>
210101	Үндсэн цалин	103,205,412.12	106,330,776.00
210102	Нэмэгдэл	24,584,219.00	26,918,665.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,380,000.00	16,452,000.00
210104	Урамшуулал	15,000,000.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20,149,787.49</b>	<b>19,718,654.76</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,868,665.34	13,709,836.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,415,942.79	1,562,519.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,104,593.63	1,258,970.09
210204	Ажилгүйдлийн даатгал	276,145.15	287,362.75
210205	Эрүүл мэндийн даатгал	2,484,440.58	2,899,965.78
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>126,225,000.00</b>	<b>126,225,000.00</b>
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,629,550.68</b>	<b>8,592,848.82</b>
210401	Бичиг хэрэг	5,244,420.00	2,618,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,791,100.00	1,230,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,839,247.68	2,569,843.82
210404	Ном, хэвлэл	00.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,000.00	605,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,904,783.00	1,168,205.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,339,700.00</b>	<b>1,236,960.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,339,700.00	1,236,960.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,994,125.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	11,084,200.00	8,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>747,900.00</b>	<b>00.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	747,900.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,742,200.00</b>	<b>61,584,953.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,008,700.00	57,752,669.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	114,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,619,000.00	1,717,784.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,091,918.71</b>	<b>35,983,029.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,100,000.00</b>	<b>14,327,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	13,917,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	410,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,991,918.71</b>	<b>21,655,529.42</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,991,918.71	21,655,529.42
213304	Хөрөнгийн	00.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,908,087.00</b>	<b>1,249,913.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	00.00	00.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,908,000.00</b>	<b>1,250,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,908,000.00</b>	<b>1,250,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,908,000.00</b>	<b>1,250,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,908,000.00	1,250,000.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-3,908,000.00</b>	<b>-1,250,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>87.00</b>	<b>-87.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>87.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>87.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	859,650,551.83	14,314,724,236.00	209,617,174.92	00.00	15,383,991,962.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	245,701.00	00.00	245,701.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>859,650,551.83</b>	<b>14,314,724,236.00</b>	<b>209,862,875.92</b>	<b>00.00</b>	<b>15,384,237,663.75</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	49,654,850.87	00.00	49,654,850.87
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>859,650,551.83</b>	<b>14,314,724,236.00</b>	<b>259,517,726.79</b>	<b>00.00</b>	<b>15,433,892,514.62</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-296,216.00	00.00	-296,216.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>859,650,551.83</b>	<b>14,314,724,236.00</b>	<b>259,221,510.79</b>	<b>00.00</b>	<b>15,433,596,298.62</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,809,780.65	00.00	20,809,780.65
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>859,650,551.83</b>	<b>14,314,724,236.00</b>	<b>280,031,291.44</b>	<b>00.00</b>	<b>15,454,406,079.27</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>381,687,300.00</b>	<b>360,064,445.58</b>	<b>-21,622,854.42</b>	<b>94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>381,687,300.00</b>	<b>360,064,445.58</b>	<b>-21,622,854.42</b>	<b>94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>367,359,800.00</b>	<b>345,736,945.58</b>	<b>-21,622,854.42</b>	<b>94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>168,156,500.00</b>	<b>149,701,441.00</b>	<b>-18,455,059.00</b>	<b>89</b>
210101	Үндсэн цалин	109,506,400.00	106,330,776.00	-3,175,624.00	97
210102	Нэмэгдэл	42,270,100.00	26,918,665.00	-15,351,435.00	64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,380,000.00	16,452,000.00	72,000.00	100
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,701,100.00</b>	<b>19,718,654.76</b>	<b>-2,982,445.24</b>	<b>87</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,974,900.00	13,709,836.76	-2,265,063.24	86
210202	Тэтгэмжийн даатгал	1,681,600.00	1,562,519.38	-119,080.62	93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,345,200.00	1,258,970.09	-86,229.91	94
210204	Ажилгүйдлийн даатгал	336,300.00	287,362.75	-48,937.25	85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,363,100.00	2,899,965.78	-463,134.22	86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>126,225,000.00</b>	<b>126,225,000.00</b>	<b>00.00</b>	<b>100</b>
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00	00.00	100
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,895,200.00</b>	<b>7,843,024.82</b>	<b>52,175.18</b>	<b>99</b>
210401	Бичиг хэрэг	2,268,700.00	2,268,700.00	00.00	100
210402	Тээвэр, шатахуун	1,230,500.00	1,230,500.00	00.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,621,600.00	2,570,019.82	51,580.18	98
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	00.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	605,600.00	605,600.00	00.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,800.00	1,168,205.00	-595.00	100
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,237,600.00</b>	<b>1,236,960.00</b>	<b>-640.00</b>	<b>100</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,237,600.00	1,236,960.00	-640.00	100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>100</b>
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	00.00	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,144,400.00</b>	<b>39,011,953.00</b>	<b>-132,447.00</b>	<b>100</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,905,900.00	35,904,669.00	-1,231.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	00.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	104,000.00	00.00	-104,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	114,500.00	00.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00	-20,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,992,784.00	-7,216.00	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,327,500.00</b>	<b>14,327,500.00</b>	<b>00.00</b>	<b>100</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,327,500.00</b>	<b>14,327,500.00</b>	<b>00.00</b>	<b>100</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,917,500.00	13,917,500.00	00.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	00.00	100
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>381,687,300.00</b>	<b>360,064,358.58</b>	<b>-21,622,941.42</b>	<b>94</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>381,687,300.00</b>	<b>360,064,358.58</b>	<b>-21,622,941.42</b>	<b>94</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	381,687,300.00	360,064,358.58	-21,622,941.42	94
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>87.00</b>	<b>87.00</b>	<b>0</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>0</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>0</b>
610001	Төсвийн байгууллага	01	01	00	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>00</b>	<b>100</b>
620001	Удирдах ажилтан	01	01	00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	00	100
620003	Үйлчлэх ажилтан	01	01	00	100
620004	Гэрээт ажилтан	00	00	00	00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>30,605,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>30,605,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		30,573,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,725,000.00
210401	Бичиг хэрэг		1,325,000.00
210402	Тээвэр, шатахуун		00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		00.00
210404	Ном, хэвлэл		400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		6,000,000.00
210604	Урсгал засвар		6,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		22,848,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		21,848,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>32,500.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		32,500.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		00.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		00.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>30,605,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>30,605,500.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		6,125,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		15,480,500.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монголын уран зургийн галерейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Б.Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд мөнгөн кассын ажиллаганы журмыг мөрдөж ажиллах, ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг удирдах дээд байгууллагад хандаж ашиглалтын хугацааг шийдүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 21-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Мэдээлэл-Аудит”ХХК-ийн захирал Д.Товуудорж, аудитор Н.Ганданбаавар, аудитор Д.Туяа, аудитор Э.Отгонзаяа, шинжээч Ц.Отгонжаргал, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын уран зургийн галерейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монголын уран зургийн галерей нь орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдтэй олон түмнийг танилцуулах, дүрслэх урлагаар дамжуулан үзэгчдэд гоо зүйн болон урлагийн боловсрол олгох,
- 1921 оны Ардын Хувьсгал ялснаас хойш өнөөдрийг хүртэлх үе үеийн авьяаслаг уран бүтээлчдийн бүтээсэн уран зураг, уран баримал, уран сийлбэр, хөөмөл, хатгамал, зээгт наамал, өрөг урлал гээд дүрслэх урлагийн бүхий л төрлийн 4000 гаруй бүтээл тус галерейд хадгалагдаж байна. Жил бүр дүрслэх урлагийн шилдэг бүтээлээр сан хөмрөгөө баяжуулж, судлан сурталчилж, хадгалж хамгаалан олон түмэнд дэлгэн толилуулдаг.
- Монголын уран зургийн уламжлал, дэг жаягийн давтагдашгүй онцлогийг шингээсэн орчин үеийн бүтээлийг олон улсад таниулж, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц бүтээлч орчин бүрдүүлэх, түүхийн дурсгалт бүтээлүүдийн хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын багц хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монголын уран зургийн галерей нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны хяналт, шинжилгээ, дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Монголын уран зургийн галерейн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Соёлын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 442,525.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,425.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 443,172.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,431.7 мянган төгрөгөөр өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монголын уран зургийн галерейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,185.9 мянган төгрөгөөр буюу 0.13 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.087	0.00	-0.87
Авлага	18,891.2	7,675.3	-11,215.8
Бараа материал	82,558.7	81,992.9	-565.8
Үндсэн хөрөнгө	15,332,770.2	15,364,737.8	31,967.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,434,220.2</b>	<b>15,454,406.1</b>	<b>20,185.9</b>
Өр төлбөр	327.7		-327.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,433,892.5	15,454,406.1	20,513.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,434,220.2</b>	<b>15,454,406.1</b>	<b>20,185.9</b>

Авлага дансны үлдэгдэл 7,675.3 мянган төгрөг болж 11,215.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн 4,980.0 мянган төгрөгийн, олон жил болсон авлагуудын авлага үүссэн, бүртгэсэн шалтгаануудыг тодруулж ажилласны үр дүнд 6,640.0 төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй

2009-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 7,271.1 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 81,992.9 мянган төгрөг болж 565.8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдэл нөөцөөс ашиглаж, бараа материалын нөөцийг зохистой удирдаж ажилласан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 2006 онд худалдаж авсан ашиглалтгүй удсан 2,137.5 мянган төгрөгийн 225 ширхэг “Монгол ахуй” ном байна. Энэ нь Арт шоп-д борлуулахаар тавьсан боловч үйлчлүүлэгчид хэвлэгдсэн оноос шалтгаалан худалдан авдаггүй, хөдөлгөөнгүй бараа болсон байна.

Үндсэн хөрөнгө 15,364,067.9 мянган төгрөг болж 31,900.9 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн нэмэлт орлогын эх үүсвэрээр болон хандиваар, үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан зэргээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 975.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2020 оны 755 дугаар тогтоолоор 1,589.1 мянган төгрөг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/636 дугаар тушаалаар 37,800.0 мянган төгрөг, Соёлын сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар 12,00.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн 52,364.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардал 20,167.0 мянган төгрөгөөр буурч, 296.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг өмнөх аудитын зөвлөмжөөр залруулсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 669.8 мянган төгрөг болж 66.7 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 275.0 мянган төгрөгөөр өссөн, тайлант хугацааны хорогдлын зардал 208.3 мянган төгрөгөөр буурсан байна.

ТӨБЗГ-ын 2020 оны А/1/1136 дугаар албан бичгийн дагуу 8,210.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,454,406.1 мянган төгрөг болж 20,809.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн өсөлт юм.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 28,198.2 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн байгууллагын өөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор бүх нийтийн хөл хорио зэргээс болж үйлчлүүлэгчийн тоо буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 647.0 мянган төгрөгөөр буюу 0.15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь 1 хүн тэтгэвэрт гарч мөнгөн тэтгэмж авсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 296.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны элэгдлийн зардлыг залруулсантай холбоотой.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,092,567.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,092,567.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.



Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 710,880.5 мянган төгрөгөөр бууруулж 381,687.3 мянган төгрөгөөр баталсан байна. Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, олон улсын галерейн жишигт хүргэхийн тулд "Музейд заавал шаардлагатай жишиг" MNS 5634:2006 стандартад заасан галерейд зайлшгүй шаардлагатай байгаа куратор, тайлбарлагч, сэргээн засварлагч, урлагийн боловсролын ажилтан, эрдэм шинжилгээний ажилтнаар орон тоогоо нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа мөн галерейн сан хөмрөгүүдэд хадгалагдаж буй түүх соёлын үнэт өв болох бүтээлүүдийн хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг сайжруулах зэрэг байгууллагад тулгамдаж буй асуудлуудыг төсвийн төсөл, төсөөлөлд тусгаж боловсруулсан байна. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор хойшлогдож төсвийн төслөөс буурч батлагдсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2020 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 381,687.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 381,687.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 381,687.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 360,064.4 мянган төгрөгийг зарцуулж 21,622.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360,064.4 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 18,455.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,982.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 52.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 132.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 0.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 6,125.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 9,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,480.5 мянган төгрөг, нийт 30,605.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа, материалын зардалд 1,725.0 мянган төгрөг, урсгал засварт 6,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 22,848.0 мянган төгрөг, нийт 30,573.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 32.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,663.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн, 22,742.6 мянган төгрөгийн нийт 8 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	2	6,663.5	2	6,663.5			
Зөвлөмж	8	22,742.6	6	22,742.6	2		25.0
Нийт дүн	10	29,406.1	8	29,406.1	2		25.0

/мянган.төг/

Өмнөх оны аудитаар өгсөн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Түүх соёлын дурсгалт зүйлсийн 2014 оны дахин үнэлгээний нэмэгдэл болох 14,314,724.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд хөрөнгө /бүтээл/-ийн нэр төрлөөр ангилж бүртгээгүй, бөөн дүнгээр тусгасныг салган бүртгэх, Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3659 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрүүг арилгах гэсэн 2 зөвлөмж хэрэгжээгүй байгаад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,533.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,276.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,257.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 07 сарын 06-ны өдрийн 364 дугаар тогтоолын дагуу 18,057.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 9,781.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,276.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий Тоёота Ланд крузейр прадо 2056 УБЗ, арал KZJ950093325 марк бүхий автомашиныг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсөн боловч балансаас хасах зөвшөөрөл ирээгүй, үндсэн хөрөнгө борлуулсан орлого орж ирээгүй байхад балансаас хассан байсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 3 аудитын зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Түүх соёл, музейн дурсгалт зүйлс дансанд бүртгэлтэй байгаа үзмэрүүдийг 2014 онд дахин үнэлсэн ба уг дахин үнэлгээг 21 гэсэн нэрээр "Дахин үнэлгээ" гэсэн хөрөнгө үүсгэн бөөн дүнгээр бүртгэсэн байсныг хөрөнгө тус бүрээр салгаж бүртгэх талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмж биелэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 20.2.10 "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

2. Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3659 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3.366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрүүг арилгах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмж биелэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10 "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2,257.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Монголын уран зургийн галерейн Түүх соёлын дурсгалт зүйлсийн 2014 оны дахин үнэлгээний нэмэгдэл болох 14,314,724.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд хөрөнгө /бүтээл/-ийн нэр төрлөөр ангилж бүртгээгүй, бөөн дүнгээр тусгасныг салган бүртгэх ажил хийгдэж байгаа боловч Ковид 19 цар тахалтай холбоотойгоор төв архивын дахин үнэлгээний тайлангийн эх хувьтай тулган үзэх боломжгүй */байгууллагад байгаа дахин үнэлгээний тайланд бөөн дүнгээр бичсэн тайлан байгаа боловч хөрөнгө тус бүрээр үнэлсэн тайлан байхгүй байна/*, Өв сангийн Регистр программын дүнг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай тулган шалгах ажил хийгдэж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

- Өөрийн үйл ажиллагааны орлогыг бэлэн мөнгөний орлогын кассаар дамжуулахгүй хурааж байгаад сард 1 удаа харилцах дансанд тушааж байна.

###### **1.2. Эрсдэл:**

- Сангийн Яамнаас гаргасан холбогдох журам, заавар мөрдөгдөхгүй байх, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангахгүй байх.

###### **1.3. Өгсөн зөвлөмж:**

- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт " Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6"Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн кассаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.", 7.2."Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна" заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй.

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

- Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

##### **2. Бараа материал данстай холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

- Бусад хангамжийн материал дансанд түлхүүрийн оосор 82 ш буюу 410.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг биетээр хүлээн аваагүй байхад орлогоор бүртгэж авсан байна.

###### **2.2 Эрсдэл:**

- Санхүүгийн тайлагналын бодитой оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангахгүй байна.

###### **2.3 Өгсөн зөвлөмж:**

- НББ-ын тухай хуулийн 4.1.2 "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална" 5.1.4 санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх зарчмыг баримталж ажиллах.

###### **2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

- Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

##### **3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### **3.1 Илрүүлэлт:**

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаас өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 70,021.2 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 127 ш хөрөнгө байна.

### 3.2 Эрсдэл:

- УСНББОУС-17, хууль, журам хэрэгжихгүй байх.

### 3.3 Өгсөн зөвлөмж:

- УСНББОУС-17 14 дүгээр зүйл Хүлээн зөвшөөрөлт “Үндсэн хөрөнгийн өртгийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө ...б.Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхыг найдвартай хэмжиж чадах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 3-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай зөвшилцөж тогтоох" заалтуудыг мөрдөж ажиллах.

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

## 4.Цалинтай холбоотой асуудал

### 4.1 Илрүүлэлт:

- Татварын суутган тайлангаар тайлагнасан цалингийн дүн, цалингийн дэлгэрэнгүй журналаас 1,847.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

### 4.2 Эрсдэл:

- Хууль, журам хэрэгжихгүй байх.

### 4.3 Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 6.3.1."Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

### 4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах санал өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/67/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монголын уран зургийн галерей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Монголын уран зургийн галерейн Түүх соёлын дурсгалт зүйлст 2014 онд дахин үнэлгээ хийж нэмэгдэл болох 14,314,724.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд хөрөнгө /бүтээл/ бүрээр биш нэг бөөн дүнгээр тусгасан.		Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
2	Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3659 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3.366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.		Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
3	Өөрийн үйл ажиллагааны орлогыг бэлэн мөнгөний орлогын кассаар дамжуулахгүй хурааж байгаад сард 1 удаа харилцах дансанд тушааж байна		Зөвлөмж	Нягтлан	Л.Болдбаатар
4	Түүврийн аргаар хийсэн хяналтын тооллогоор зэс түлхүүрийн оосор 82 ш буюу 410.0 мянган төгрөгөөр дутсан нь захиалсан бараагаа хүлээн аваагүй байж орлогод авсан байна	410.0	Зөвлөмж	Нягтлан	Л.Болдбаатар
5	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаас өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 70,021.2 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 127 ш хөрөнгө байна.		Зөвлөмж	Захирал, нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
6	Татварын суутган тайлангаар тайлагнасан цалингийн дүн, цалингийн дэлгэрэнгүй журналаас 1,847.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна	1,847.1	Зөвлөмж	Нягтлан	Л.Болдбаатар
7	Шилэн дансны тухай 6-р зүйлд заасан 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна		Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
<b>ДҮН</b>		<b>2,257.1</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 50/АД/70070  
САГ-2021/67/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Түүх соёл, музейн дурсгалт зүйлс дансанд бүртгэлтэй байгаа үзмэрүүдийг 2014 онд дахин үнэлсэн ба уг дахин үнэлгээг 21 гэсэн нэрээр "Дахин үнэлгээ" гэсэн хөрөнгө үүсгэн бөөн дүнгээр бүртгэсэн байсныг хөрөнгө тус бүрээр салгаж бүртгэх талаар өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10 "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал Б.Сарантуяа, нягтлан бодогч Л.Болдбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Д.ТОВУУДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 51/А0170090  
СЭГ-2021/67/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3659 ширхэг 15,073,161,407.0 (арван таван тэрбум далан гурван сая нэг зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун долоо) төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3366 ширхэг 15,249,905,700.0 (арван таван тэрбум хоёр зуун дөчин өсөн сая өсөн зуун таван мянга долоон зуу) төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрүүг арилгах талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.10 "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгаг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал Б.Сарантуяа, нягтлан бодогч Л.Болдбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭГН ҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГСЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ДАШДАВАА

МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Вага тойргуу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.10\ichig\_kherog\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар68.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 52/А070070  
САГ-2021/67/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 149 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үний зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал Б.Сарантуяа, нягтлан бодогч Л.Болдбаатар нарт даалгав.


**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Д.ТОВУУДОРЖ





## ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines spanning the width of the page, intended for a student to write their conclusion.